



САНГИЙН ЯАМ

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Сангийн сайдын дангаар болон бусад сайдтай хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний 2023 оны 4 дүгээр сарын байдлаарх хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлгээ өгсөн тайланг танилцуулж байна.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2023 оны 4 дүгээр сарын байдлаарх хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд нийт 32 арга хэмжээнээс Сангийн сайдын хариуцан хэрэгжүүлэх үүрэгт хамааралгүй 3 арга хэмжээ, үнэлэх боломжгүй 3 арга хэмжээг хасаж тооцвол 26 арга хэмжээнээс 18 арга хэмжээ 100.0 хувийн, 5 арга хэмжээ 90.0 хувийн хэрэгжилттэй, 3 арга хэмжээ 70.0 хувийн хэрэгжилттэй ерөнхий дүнгээр 94.6 хувьтай байна.

**Засгийн газрын Үйл ажиллагааны хөтөлбөр
Сангийн яам 2023 оны 4 сар**

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2023 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
НЭГ. КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО							
1	1.1.9. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн чөлөөт мөнгөн хөрөнгийг оновчтой удирдах замаар Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээ, зардлыг бууруулах арга хэмжээ авна.	1. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн чөлөөт мөнгөн хөрөнгийг оновчтой удирдах замаар Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээ, зардлыг бууруулах арга хэмжээг авна.	2021 - 2024		Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Энэ ажлын хүрээнд 2023 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: Гадаад зээлийн эх үүсвэрээс дотоодод дамжуулан зээлдүүлсэн зээлийн хүрээнд 2023 оны 1-р улирлын байдлаар нийт 32.3 тэрбум төгрөг төвлөрүүллээ. Үүнээс үндсэн төлбөрт 24.6 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 7.6 тэрбум төгрөг төвлөрлөө. Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдээс 12.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн. Засгийн газраас хэрэгжүүлсэн 4 мянга, 100 мянган айлын орон сууцны хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийн үндсэн төлбөрт 2.2 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 1.2 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүллээ. Хөдөө аж ахуйг дэмжих сангаас авах Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр бүрдүүлсэн улаан буудайтай холбогдох авлагын хугацаа хэтэрсэн үлдэгдлээс 3.6 тэрбум төгрөгийг барагдуулсан.	100%
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО							
2	2.1.7. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой арга,	10. Эрүүл мэндийн	2021 - 2024		Эрүүл мэндийн даатгалын цахим тогтолцоог бий	Эрүүл мэндийн байгууллага (төрийн болон хувийн өмчийн бүх төрлийн эмнэлэг, эмийн сан, сувилал, анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлж буй өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв)-ийн Эрүүл мэндийн даатгалын	100%

	хэлбэрийг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлж, эрсдэлийн сан байгуулна.	даатгалыг цахимжуулна.			болгож, бүх шатны эрүүл мэндийн байгууллагыг холбоно.	ерөнхий газартай гэрээ байгуулах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний сонгон шалгаруулалт, гэрээлэлт, нэхэмжлэл илгээлт, нэхэмжлэл хянах зэрэг үйл ажиллагааг бүрэн цахимжуулсан. Эрүүл мэндийн даатгалын цахим тогтолцоог сайжруулахад зориулан Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсвийн хүрээнд олон улсын жишигт нийцсэн орчин үеийн сервер болон программ хангамжийн хөгжүүлэлтийг нэвтрүүлсэн. Тулгамдаж буй гол асуудал нь Эрүүл мэндийн даатгалын сантай гэрээ байгуулсан зарим эрүүл мэндийн байгууллага (анхан шат, зарим лавлагаа шатны эмнэлэг)-ын дотооддоо ашиглаж буй программ хангамжийн хөгжүүлэлт болон техникийн хүчин чадлыг хангалтгүй байгаагаас шалтгаалан нэгдсэн цахим тогтолцоонд холбогдсон боловч нэхэмжлэл илгээхэд хүндрэл үүсэж байна. Цаашид эрүүл мэндийн байгууллагуудын программ хангамжийн хөгжүүлэлтийг сайжруулах, сервер, интернет, компьютер болон дагалдах тоног төхөөрөмж зэрэг техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.	
3		11. Төрөөс хариуцах иргэдийн шимтгэл, албан бус салбарын даатгуулагчдын хамрагдалт, шимтгэлийн хэмжээг өсгөх замаар Улсын төсөв /ЭМДС/гийн	2021 - 2024		ЭМД-ын тухай хуулийн 8.1.3-т заасан даатгуулагчийн сард төлөх шимтгэлийн хувь хэмжээг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 3-аас доошгүй хувиар, 6.1.4-т заасан	Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн батлагдсан төсвийн шимтгэлийн орлого Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу албан журмаар даатгуулагчаас 2 хувь, ажил олгогчоос 2 хувь, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагч болон бусад сайн дурын даатгуулагчаас сард хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2 хувь, 0-18 насны хүүхдээс сард хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1 хувь, сайн дураар даатгуулж буй гадаадын иргэн сард хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2 хувиар тус тус шимтгэл төлөхөөр тооцоолж тусгасан. 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хөдөлмөрийн	90%

		орлогыг нэмэгдүүлнэ.			даатгуулагчийн шимтгэлийн хувь, хэмжээг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 5-аас доошгүй хувиар тус тус тогтооно.	хөлсний доод хэмжээ нэмэгдсэнтэй уялдуулан шимтгэлийн хувь хэмжээг нэмэгдүүлэх тогтоол, шийдвэр 2022-2023 онд гаргаагүй. Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлсэн улсын төсвийн орлого 2021 онд 580.4 тэрбум төгрөг, 2022 онд 704.1 тэрбум төгрөг байсан бол 2023 онд 914.4 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн.	
4	2.6.3. Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, үндэсний агуулгатай инновац шингэсэн соёлын бүтээлч үйлдвэрлэл-инновацын салбарыг хөгжүүлж, монгол брэндийг бий болгож, соёл, урлагийн эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.	5. Соёлын удирдлага, зохион байгуулалтын нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгож, санхүүжилтийн олон эх үүсвэртэй, хүртээмжтэй, үр ашигтай механизмыг бүрдүүлэн соёлын үйлчилгээг иргэдэд чанартай, шуурхай хүргэнэ.	2021 - 2025	11 аймагт Соёл, урлагийн газрын барилгыг барьж ашиглалтад оруулна. 10 аймагт Соёл, урлагийн газрын барилга угсралтын ажлыг эхлүүлнэ. Соёл, урлагийн байгууллагыг батлагдсан стандартын дагуу зохион байгуулж ажиллуулна.	2023 оны төсвийн төсөлд шинээр хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ тусгахгүй гэсэн зарчмыг баримталсан тул тухайн төсөл, арга хэмжээ тусгагдаагүй тул үнэлэх боломжгүй	100%	
ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО							

5	3.1.2. Эдийн засгийн эрсдэлээс сэргийлж, эдийн засаг өсөлттэй үед төсвийг тогтворжуулж, хямралтай үед тэлэх мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлнэ.	1. Эдийн засгийн эрсдэлээс сэргийлж, эдийн засаг өсөлттэй үед төсвийг тогтворжуулж, хямралтай үед тэлэх мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлнэ.	2020 - 2024		Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Цар тахлын хүндрэлээс шалтгаалж эдийн засгийн өсөлт саарсан 2020-2021 онуудад төсвийг тэлэх, мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээ хэрэгжүүлсэн. Энэ хүрээнд нийгмийн халамжийн зардлыг нэмэгдүүлэх, албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх, иргэд аж ахуйн нэгжүүдийн хэрэглээний зардлыг төрөөс хариуцах зэрэг мөчлөг сөрсөн төсвийн бодлогыг хэрэгжүүлсэн. Харин 2022 оноос эхлэн эдийн засгийн өсөлт хурдсаж байгаатай холбогдуулан инфляцын өсөлтийг сааруулах болон төсвийн тэнцлийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлж байна. 2023 онд төсвийн хэмнэлтийн бодлогыг үргэлжлүүлэн, гүйцэтгэлтэй уялдуулсан цалингийн шинэчлэл болон эхлүүлсэн хөрөнгө оруулалтын төслүүдийг эцэслэх, эдийн засгийн өсөлтийг хурдасгах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.	100%
6	3.1.3. Банкны салбарын шинэчлэлийг богино хугацаанд хийж, банк, санхүүгийн байгууллагуудын өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг өртөг багатай санхүүжилтээр дэмжиж, банкны зээлийн сарын хүүг 1 хувиас хэтрүүлэхгүй болгож, эрсдэл	1. Банкны тухай хууль, Төвбанкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль зэрэг хууль, тогтоомж холбогдох журамд	2020 - 2024		Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Монгол Улсын Их Хурлын 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар баталсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар системийн нөлөө бүхий банкнууд нээлттэй хувьцаат компани хэлбэртэй байхаар, мөн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар энэхүү шилжилтийг буюу компанийн хэлбэрээ өөрчлөх асуудлыг 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор багтаж өөрчилсөн байхаар тус тус зохицуулсан. Арилжааны банкнуудыг нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжихээс өмнө Монгол банкнаас эдгээр банкнуудад активын чанарын үнэлгээг хийх шаардлага тавигдсаны дагуу банкнуудын IPO хийх хугацааг нэг жилээр буюу 2023.06.30-ны өдөр хүртэл сунгах зохицуулалтыг УИХ-ын 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар баталсан. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Төрийн банк, Голомт банк, Хаан банкнууд олон	100%

	даах чадамжтай болгоно.	өөрчлөлт оруулна.				нийтэд нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжих анхдагч арилжааны нээлтээ хийн, хувьцаагаа олон нийтэд санал болгон, IPO амжилттай хийгээд байна. Ингэснээр IPO хийх системийн 5 банкнаас ХХБ, ХАС үлдээд байна. Арилжааны банкнууд олон нийтэд нээлттэй хэлбэрт амжилттай шилжсэнээр өөрийн хөрөнгөө нэмэгдүүлж, засаглалын хувьд илүү ил тод, нээлттэй болж, банкны салбар, хөрөнгийн зах зээл өргөжиж, эдийн засгийн өсөлтийг дэмжиж нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзэж байна.	
7	3.1.4. Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг тэтгэж, зээлийн хүүг бууруулна.	1. Санхүүгийн түрээсийн эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд Санхүүгийн түрээсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна."	2020 - 2024		Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Санхүүгийн түрээсийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн урьдчилсан тандан судалгаа, үзэл баримтлалын төсөл, зардлын тооцоолол болон үр нөлөөллийн үнэлгээг тус тус эцэслэн боловсруулаад байна.	70%
8	3.1.5. Санхүүгийн түрээсийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1. Санхүүгийн түрээсийн тухай хууль-д нэмэлт өөрчлөлт оруулах замаар хууль, эрх зүйн орчныг сайжруулна.	2020 - 2024		Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Санхүүгийн түрээсийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн урьдчилсан тандан судалгаа, үзэл баримтлалын төсөл, зардлын тооцоолол болон үр нөлөөллийн үнэлгээг тус тус эцэслэн боловсруулаад байна.	70%
9	3.1.6. Иргэдийг санхүүгийн эрсдэл, дарамтад өртөхөөс сэргийлэх, санхүүгийн	1. Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хуулийн	2020 - 2024		Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооноос Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлсэн "Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах төсөл"-ийн хүрээнд санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах нийтлэг	100%

	хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль, эрх зүйн орчныг шинээр бүрдүүлэх замаар мөнгө хүүлэлтийг таслан зогсооно.	төслийг боловсруулж УИХ-аар хэлэлцүүлэн батлуулна.				шаардлагыг тогтоож, зохицуулагч байгууллага болон Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тусгайлсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, олон нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, түүнчлэн санхүүгийн хэрэглэгчээс гаргасан санхүүгийн үйлчилгээтэй холбоотой гомдол, маргааныг шүүхийн бус журмаар хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий санхүүгийн омбудсманыг байгуулах, санхүүгийн хэрэглэгчийг өрийн дарамтад орохоос сэргийлэхтэй холбоотой хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх зохицуулалтыг тусган боловсруулсан. “Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль”-ийн төслийг эцэслэн боловсруулан, Хууль тогтоомжийн тухай хуульд заасан бүрдлийг ханган 2022 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн А-1/990 дүгээр албан бичгээр хууль санаачлагч болох Ерөнхийлөгчийн Тамгын газарт уламжилсан байна. Иймээс энэ заалтыг Сангийн яамны хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээнээс хасах саналтай байна.- Хамааралгүй	
10	3.1.8. Банк, санхүүгийн систем дэх чанаргүй зээлийг шуурхай, зардал багатай шийдвэрлэх хууль, эрх зүйн шинэчлэл хийнэ.	1. Банк, санхүүгийн систем дэх чанаргүй зээлийг шуурхай, зардал багатай шийдвэрлэх хууль, эрх зүйн шинэчлэл хийнэ.	2020 - 2024		Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Хуулийн этгээдийн төлбөрийн чадваргүйдлийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх, төлбөрийн чадваргүй хуулийн этгээдийг дахин хөрөнгөжүүлэх, татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулахаар Засгийн газраас Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийг 2022 оны 3 дугаар сарын 14-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн. Хуулийн төсөлд хуулийн этгээдийн төлбөрийн чадвартай эсэхийг тогтоох, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх, нэхэмжлэлийн шаардлагыг ангилах, хангах, хэрэг гүйцэтгэгчийн томилох, чөлөөлөх, нэхэмжлэгчдийн хурал, түүний эрх хэмжээ, хуралд оролцох саналын эрх, хуваарилагдах хөрөнгө, хуулийн этгээдийг дахин хөрөнгөжүүлэхтэй холбогдсон асуудлыг нарийвчлан тусгасан. УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны	70%

						2022.10.12-ны өдрийн хуралдаанаар тус хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжсэн.	
11	3.1.9. Хугацаа тулсан гадаад өр төлбөрийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр шийдвэрлэн Засгийн газрын өрийн дарамтыг бууруулж, санхүүгийн нөөцийг бүрдүүлнэ.	1. Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг"-т тусгасны дагуу Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрийг дахин санхүүжүүлнэ.	2020 - 2024		Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр олон улсын санхүүгийн зах зээлд "Сенчири-2" бондыг арилжаалж хугацаа нь тулаад байсан 2023-2024 онд эргэн төлөгдөх нөхцөлтэй Гэрэгэ болон Хуралдай бондын нийт 1.1 тэрбум ам.долларын бондын зарим хэсгийг дахин санхүүжүүлэх өрийн зохицуулалтын арга хэмжээг амжилттай авч хэрэгжүүлэн Засгийн газрын өрийн дарамтыг бууруулж, ирэх жилүүдэд төсөв, санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг ханган ажилласан. Дээрх өрийн зохицуулалтын арга хэмжээний хүрээнд үйлчилгээ үзүүлэгч олон улсын хөрөнгө оруулалтын 4 банк, зээлжих зэрэглэл тогтоогч 2 байгууллага, олон улсын болон дотоодын хуулийн нийт 4 фирм, гуравдагч үйлчилгээ үзүүлэгч 6 байгууллагуудтай хамтран ажилласан бөгөөд дээрх байгууллагуудын үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэлийг хүлээн авч 2023 оны улсын төсвөөс санхүүжүүлсэн. Монгол улсын Засгийн газар 2017 онд авсан 800 сая долларын "Гэрэгэ" бондын өрийн үлдэгдэл болох 368,4 сая доллар буюу 1,280.8тэрбум төгрөгийг 2023 оны 4 сарын 28-нд бүрэн төлж барагдууллаа.	100%
12	3.1.10. Гадаад худалдааг дэмжсэн гаалийн үйлчилгээг хялбаршуулж, иргэдийг хууль бус, хуурамч бараанаас сэргийлэх, байгалийн баялгаас татварыг бүрэн хураахад	1. Барааны борлуулалтын шат дамжлага бүрийг бараа бүртгэлийн нэгдсэн системээр дамжуулан бүртгэж иргэд гар утасны "и-	2020 - 2024		Бүх төрлийн хүнсний барааг Бараа бүтээгдэхүүний нэгдсэн системээр дамжуулан бүртгэсэн байна.	Бараа, бүтээгдэхүүн, ашигт малтмалыг үйлдвэрлэл, борлуулалт, импорт, экспортын үе шат бүрээр цахим төлбөрийн баримт, гаалийн мэдүүлэг, гаалийн лабораторийн дүгнэлтэд үндэслэн татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэх журмын төслийг боловсруулан Сангийн сайдын А/89 дүгээр тушаалаар 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр батлуулсан. Түүнчлэн и-баримтын аппликейшн ашиглан иргэд онцгой албан татвартай барааны гарал үүслийг хянах боломжийг бүрдүүлсэн. Түүнчлэн Гааль, татварын	100%

	чиглэсэн гаалийн шинэчлэлийг үргэлжлүүлнэ.	баримт" аппликейшн ашиглан тамхи, согтууруулах ундаа зэрэг онцгой албан татвартай бүх төрлийн бараа, эмийн бүтээгдэхүүн, мах, махан бүтээгдэхүүний гарал үүсэл, чанар зэрэгт хяналт тавих боломжийг бүрдүүлнэ.				бүртгэл, мэдээллийн санд ашигт малтмалын бүтээгдэхүүнийг олборлолт, борлуулалт, экспортын үе шат бүрд хийгдсэн гэрээнд үндэслэн бүртгэж, хасалтыг дотоодод борлуулсан тохиолдолд үйлдсэн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн баримтад, экспортолсон тохиолдолд гаалийн мэдүүлэгт үндэслэн хасалт хийж байна.	
13	3.1.11. Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар татварын үйлчилгээг иргэд, татвар төлөгчдөд хүндрэлгүй болгож, татварын суурийг нэмэгдүүлнэ.	1. Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар татварын үйлчилгээг иргэд, татвар төлөгчдөд хүндрэлгүй болгож, татварын суурийг нэмэгдүүлэх зорилгоор	2020 - 2023		Системийн туршилтыг хийж, нэвтрүүлсэн байна.	"И-Баримт" цахим төлбөрийн баримтын системээр дамжуулан татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар татварын үйлчилгээг иргэд, татвар төлөгчдөд хүндрэлгүй болгож, татварын суурийг нэмэгдүүлэх зорилгоор үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, малын тоо толгойн албан татвар, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, газрын төлбөр, галт зэвсгийн албан татвар зэрэг татваруудын нэхэмжлэлийг цахимаар хүргүүлж, иргэн НӨАТ-ын буцаан олголтоос суутгуулах эсхүл богино хугацаанд цахимаар түргэн шуурхай, хялбар төлөх боломжийг бүрдүүлж, нэвтрүүлсэн болно.	100%

		газар, үл хөдлөх эд хөрөнгө, буу, авто тээвэр зэрэг хувь хүнд хамаарах бүхий л татварын нэхэмжлэлийг цахим төлбөрийн баримтын системээр хүргүүлэн, богино хугацаанд цахимаар, хялбар төлөх боломжийг олгоно.					
14	3.1.12. Төсөв, санхүүгийн нэгдсэн цахим систем нэвтрүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, үр ашигтай болгож, гадаадын зээл, тусламж, төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг ил тод, хэмнэлттэй	1. Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлага мэдээллийн системд бүртгэлтэй төрийн албан хаагчийн мэдээлэлд суурилсан Төрийн албаны цалин хөлсний нэгдсэн системийг	2021 - 2024		Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Сангийн яам төсвийн байгууллага, улсын төсөвт үйлдвэрийн газруудын орон тоо, цалин хөлсний зардлын хуваарилалтад хяналт тавих, төсвийн үр ашиг, сахилга батыг сайжруулах зорилгоор ТАЦНС-ийн функциональ шаардлага болон бизнес процесс боловсруулах, турших программ хангамж хөгжүүлэх ажлыг ГТСМТТ улсын төсөвт үйлдвэрийн газартай хамтран гүйцэтгэж, албан хаагчдын цалин хөлсийг системээр тооцоолон, албан хаагчдын арилжааны банкны нэрийн дансанд гүйлгээ илгээж байна. ТАЦНС-ийг улс орон даяар үе шаттайгаар нэвтрүүлэх Засгийн газрын 2020 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 163 дугаар тогтоол батлагдсан. Тогтоолын хэрэгжилтийг хангаж 2020 оны 9 дүгээр сараас үе шаттайгаар нийт 4,375 байгууллагын нягтлан бодогч, дарга нар хэрэглэгчээр бүртгүүлэн нэвтэрч цалин хөлс бодож	100%

	зарцуулах нөхцөл бүрдүүлнэ.	улсын хэмжээнд нэвтрүүлнэ. Салбаруудын орон тоонд хяналт тавьж, давхардсан болон илүүдэл орон тоог илрүүлэх замаар орон тоог дахин хуваарилах, бууруулах зэргээр цалин хөлсний төлөвлөлтийг оновчтой болгож, зардлын өсөлтийг тогтворжуулна.				эхэлсэн нь 100 хувийн гүйцэтгэлтэй байна.ТАЦНС, Төрийн сангийн удирдлагын цахим систем, Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системийн хэрэглэгчдийн гүйлгээний цахим баталгаажуулалтыг Эрхийн бүртгэлийн сангаар дамжуулан хийдэг болсноор нэг ажил үүргийг давтан хийдэг байдлыг хялбаршуулж мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллах бололцоо бүрдлээ.Сангийн сайдын 2021 оны 109 тоот тушаалаар баталсан “Төрийн албаны цалингийн нэгдсэн системийн үйл ажиллагааны заавар”-ын дагуу Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтнүүд, төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагч нарын төсвийн мэргэжилтнүүд, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга болон ТЕЗ-ын ерөнхий нягтлан бодогч нарыг ТАЦНС-д хэрэглэгчээр холбох ажил бүрэн хийгдсэн. Ингэснээр харъяа байгууллагуудын орон тоо, цалин хөлсний мэдээлэлд дүн шинжилгээ хийх боломжтой болсон.(i) Төсвийн мэргэжилтнүүдэд зориулсан тайлангийн хөгжүүлэлтийг сайжруулах, (ii) ТАХ-д өндөр насны тэтгэвэрт олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж болон Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгийг уг системээр дамжуулан олгох хөгжүүлэлтийн ажлыг хийж байгаа, 2023 оны 1-р улиралд нэвтрүүлэхээр байна	
15		3. Төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламж, концесс, орон нутгийн төсөв болон бусад эх үүсвэрээр	2021 - 2023		Төслүүдийн нэгдсэн мэдээллийн сантай болсон байна.	АХБ-тай хэрэгжүүлж байгаа ТСУИТҮАБТ төсөл"-ийн хүрээнд төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламж, концесс орон нутгийн төсөв болон бусад эх үүсвэрээр хэрэгжиж байгаа төслүүдийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх ажлын хүрээнд 19 аймагт сүүлийн 10 жил орон нутгийн төсвөөс хэрэгжсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг оруулж нэгтгэсэн. . Нийт 19 аймаг, нийслэлийн мэдээллийг хүлээн авч хянаж цахим системд оруулж нэгтгэсэн. Системд шинээр орон	100%

		хэрэгжиж байгаа төслүүдийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлнэ.			нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар (ОНТ) хэрэгжүүлсэн, хэрэгжүүлж буй болон төлөвлөж буй төслүүдийн мэдээллийг оруулах, улмаар улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэртэй нэгтгэн харах, төлөвлөхтэй холбогдуулан системд ОНТ дэд систем үүсгэж, төсөл бүртгэх, төлөвлөх хэсгийн хөгжүүлэлтийг хийж дуусгасан бөгөөд холбогдох мэдээллийг нийслэл, бүх дүүрэг болон аймгийн хөрөнгө оруулалтын мэргэжилтэн нарт 2023 оны 2-р сард зохион байгуулсан “Төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг- IX” сургалтын үеэр хүргэсэн. Мөн 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрөөс 2023 оны 4 дүгээр сарын 25-ны хооронд “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын цахим систем /PIMIS/”-ийн талаарх бүсчилсэн сургалтыг хийхээр төлөвлөж, сургалтыг эхлүүлээд байна. Сургалтын хүрээнд 2023 оны 03 сарын 24-25-ны өдрүүдэд Хэнтий аймагт Зүүн бүсийн сургалтыг зохион байгуулсан бөгөөд сургалтад Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгийн холбогдох албан хаагчид оролцсон. Мөн Дорноговь аймагт Говийн бүсийн сургалтыг 3-р сарын 31-ээс 4-р-сарын 1-ний өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд сургалтад Төв, Говьсүмбэр, Өмнөговь, Дундговь, Дорноговь аймгийн холбогдох албан хаагчид оролцсон. 2023 оны 04 сарын 7-8-ны өдрүүдэд Дархан-Уул аймагт Төвийн бүсийн сургалтыг Орхон, Сэлэнгэ, Хөвсгөл, Булган аймгийн холбогдох албан тушаалтнуудад зохион байгуулсан. 2023 оны 04 сарын 20-21-ний өдрүүдэд Ховд аймагт Баруун бүсийн сургалтыг зохион байгуулсан бөгөөд 2023 оны 04 сарын 11-ны өдөр агентлагуудын төсвийн хөрөнгө оруулалт, гүйцэтгэл хэрэгжилт хариуцсан албан хаагчдад зориулсан сургалтыг амжилттай зохион байгуулсан.	
16		4. Төсөв, санхүү, хөрөнгө оруулалт,	2021 - 2023	Төсөв, санхүүгийн нэгдсэн цахим	АХБ-тай хэрэгжүүлж байгаа “Төсөв, санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал төсөл”-ийн хүрээнд яамны дэргэд Мэдээллийн нэгдсэн төвийг	100%

		худалдан авалт, тайлан бүртгэл, хяналтын системийн нэгдсэн дэд бүтцийг бий болгоно.			системтэй болсон байна.	барьж ашиглалтад оруулсан. Төслийн зөвлөхүүд модуль боловсруулж, төсөв, санхүү, хөрөнгө оруулалт, худалдан авалт, тайлан бүртгэл, хяналтын системийн нэгдсэн дэд бүтэцтэй болгох ажлыг хийж байна. Хөрөнгө оруулалтын нэгдсэн мэдээллийн систем бүрдүүлэх талаар системийн зөвлөхийн баг PIMIS системийг худалдан авах ажиллагааны системтэй холбосноор тухайн төсөл, арга хэмжээний тендерийн явц болон оролцогчийн талаарх мэдээллийг авах, мөн Монголбанкны системтэй холбож захиалагч болон гүйцэтгэгчийн дансны мэдээллийг шалгах боломжтой болсон. Төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн мэдээллийн системийн хүрээнд боловсруулах 9 модулиас Бодлогын модулийн хөгжүүлэлтийг дуусгасан. Энэхүү модулийг PIMIS системтэй холбох ажлыг бүрэн хийж дууссан.	
17		5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгож төсөл, арга хэмжээний үр ашиг, хэрэгжилт, гүйцэтгэлийг сайжруулна.	2021 - 2024		Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, санхүүжүүлэх, хянахад Засгийн газрын 2021 оны 160-р тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”, мөн Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны журам болон аргачлалууд” мөрдлөг болгож байна. Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг 2022 оны 12-р сард УИХ-аар батлуулсан. Энэхүү хуульд тусгагдсан Сангийн яамны чиг үүрэгт хамаарах холбогдох журам, зааврын төслийг боловсруулах үүрэг бүхий "Ажлын хэсэг байгуулах тухай" ТНБД-ын 2023 оны 1 дүгээр сарын 02-ны өдөр А/01 тоот тушаал батлуулж, ажлын хэсгийн гишүүд журам, зааврын төслийг боловсруулж байна. Засгийн газрын 2021 оны 160-р тогтоолоор баталсан журамд нэмэлт, өөрчлөлт оруулж 2023 оны	100%

						эхний хагас жилд Засгийн газрын тогтоолоор батлуулахаар ажиллаж байна.	
18	3.1.13. Бизнесийн шударга өрсөлдөөнийг дэмжсэн, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалсан шинэчлэлийн бодлого хэрэгжүүлнэ.	5. Зар сурталчилгааны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бүтцийг бий болгож, хүн амын хүнсний болон аюулгүй байдалд сөрөг нөлөөт зар сурталчилгааг таслан зогсоох, хязгаарлах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимтэй хэрэгжүүлнэ	2020 - 2024		Хүнсний бүтээгдэхүүнийг эмтэй адилтган сурталчлах байдлаар хэрэглэгчийг төөрөгдүүлсэн зар сурталчилгаанд хяналт тавих үйл ажиллагааг эрчимжүүлнэ	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудал нь Монгол Улсын Шадар сайдын харьяа Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын эрхлэх асуудал бөгөөд жил бүр тус байгууллагын төсвийг батлан хэрэгжүүлдэг. Тухайлбал 2022 онд 36 орон тоо, 847.9 сая төгрөгийн төсөв батлагдан хэрэгжиж байна. 2023 оны төсөвт 36 орон тоо 932.5 сая төгрөг тусгагдсан байна.- Хамааралгүй	100%
19	3.1.15. Дотоодын давхар даатгал хөгжих, урт хугацааны даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлж, даатгалын салбарын эрсдэлийн	1. Даатгалын салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай, Жолоочийн	2020 - 2024		Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслүүд болон бусад бүрдүүлбэрийн хамт бусад яамдаас санал авахаар 2023.02.09-ний 01/822 тоот албан бичгээр хүргүүлсний дагуу яамдаас хуулийн төслүүдэд хариу саналаа ирүүлснийг СЗХ-той хамтарсан ажлын хэсгийн хамт судлан холбогдох зүйл, заалтуудад тусган ажиллаж байна. Яамдын саналуудыг тусгасны дараа Хууль зүй, Дотоод хэргийн яамнаас зөвшөөрлийг авч 5 дугаар сард багтаан Засгийн газарт өргөн мэдүүлэхээр бэлтгэж байна. Даатгалын багц хуулийн төсөлд даатгагч нь даатгалын гэрээний дагуу хүлээсэн үүргээ давхар даатгуулах тохиолдолд давхар	90%

	удирдлагын тогтолцоог сайжруулан салбарын тогтвортой өсөлтийг бүрдүүлнэ.	даатгалын тухай зэрэг хууль тогтоомж болон холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулна.				даатгалд шилжүүлэх даатгалын үнэлгээний 10-аас доошгүй хувийг дотоодын давхар даатгагчид даатгуулах тухай, даатгагчид давхар даатгалд даатгуулж болохоос гадна хамтын даатгал болон даатгалын эрсдэл шилжүүлэх уламжлалт бус санхүүгийн хэрэгсэл ашиглан даатгуулах зэрэг бусад эрсдэлийн удирдлагын хэлбэрүүдээр эрсдэлээ удирдаж болох заалтыг тусган оруулав. Мөн даатгагч болон бусад холбогдох этгээдүүдийн үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилтэд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх тухай, Хорооноос баталсан Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг хангуулах тухай заалтуудыг тусган оруулсан. Мөн хуулийн төсөлд ердийн болон амьдралын (урт хугацааны) даатгалын хүрээ, заагийг нарийн тодорхойлон, ердийн даатгагчийн эрхэлж болох амь нас, эрүүл мэндийн бүтээгдэхүүний төрлүүдийг тодорхой тусгаж оруулаад байна.	
20	3.1.18. Хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, хөрш орнуудын хилийн боомтуудын жишигт хүргэнэ. Хилийн заставуудын барилга, объектуудыг шинэчилж чанарыг сайжруулна.	1. Хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлж сайжруулна.	2021 - 2024	Ханги, Булган, Хавирга боомтын бүтээн байгуулалт, гаалийн хяналт шалгалтын тоног төхөөрөмжийг суурилуулж иж бүрэн сайжруулж, хилээр нэвтэрч буй уул уурхай, эрдэс бүтээгдэхүүнээс дээж авч шинжлэн, татварыг бүрэн	"Хилийн боомтын захиргаа байгуулах тухай" Засгийн газрын 2022 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн 142 дугаар тогтоолоор байгуулагдсан Хилийн боомтын захиргаа болон "Боомтын сэргэлтийн үндэсний хорооны бүрэлдэхүүн, үндэсний хорооны дүрэм, сайдын ажлын албаны орон тооны хязгаарыг батлах тухай" Засгийн газрын 2022 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 342 дугаар тогтоолоор батлагдсан Боомтын сэргэлтийн Үндэсний хороог боомтын сэргэлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд байгуулахаар шийдвэрлэсэн. Иймд боомтын шинэчлэлийн асуудал нь боомтын сэргэлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хамаарах бөгөөд Сангийн сайд дээр дурдсан үндэсний хорооны гишүүнээр оролцон ажиллаж байна. Мөн гаалийн шинэчлэлийн хүрээнд гаалийн хяналт, шалгалтын тоног төхөөрөмжийн шинэчлэл/дээж авагч тоног төхөөрөмж, рентген төхөөрөмж/-ийн ажлыг эрчимжүүлэн, өргөтгөл	100%	

					ногдуулах нөхцөл бүрдсэн байна.	шинэчлэлийн бүтээн байгуулалт хийгдэх боомтуудад ухаалаг гарцын системийн тоног төхөөрөмжийг суурилуулах ажил явагдаж байна.-Хамааралгүй	
21	3.1.21. Нийслэлээс 1000 км-ээс дээш алслагдсан бүсэд үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүд 10 дахин бага буюу 1 хувийн татвар төлөх хуулийн хөнгөлөлтийг үргэлжлүүлж, орон нутагт томоохон аж ахуйн нэгж салбараа байгуулахыг санхүү, татварын бодлогоор дэмжиж, бүсийн нэмэгдэл олгоно.	1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.5.1-д заасны дагуу нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 50 хувиар, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 90 хувиар татварын хөнгөлөлт үзүүлдэг болно.	2020 - 2024		Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Орон нутагт бизнесийн үйл ажиллагаа эрхлэх явдлыг дэмжиж, төвлөрлийг сааруулах зорилгоор Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.5.1-д заасны дагуу нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 50 хувиар, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 90 хувиар татварын хөнгөлөлт үзүүлдэг. Дээрх заалтад заасны дагуу сүүлийн 3 жилд нийт 81 тэрбум төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн бөгөөд түүнээс 2022 онд 68.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн байна.	100%
22	3.2.8. Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна:	2.1. Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах, дамжуулах хоолой барих санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэж, бүтээн	2020 - 2024		Дамжуулах хоолойн барилга, угсралтын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ. 90%	"Монгол улсад газрын тос дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлж, барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах" тендерийг УУХҮЯ-с 2021 оны 4-р сард зарласан. Үнэлгээний хорооны шийдвэрээр 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдөр техник технологийн хувьд хэрэгжих боломжтой, хамгийн бага үнийн санал ирүүлсэн "NORINCO International Cooperation" компанийг сонгон шалгаруулж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас тус компанид гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг 2021.12.3-ны өдөр хүргүүлсэн."Дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлж барих гүйцэтгэгчийг	90%

		байгуулалтын ажлыг гүйцэтгэнэ.			шалгаруулсан. Төслийг гүйцэтгэх гэрээ байгуулах эрх олгох тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулсан ба гэрээ байгуулах эрх олгох тухай Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгын хамт 2022.02.18-ны өдрийн 01/418 тоотоор ХЭГ-т хүргүүлж 2022.03.02-ны өдрийн 14 дүгээр тэмдэглэл гаргуулсан. 2022.04.18-ны өдөр талууд хамтран ажиллах ерөнхий гэрээг УУХҮЯ, МГТБҮ ТӨХХК, ЭТТ ХК, Норинко компаниуд хооронд байгуулсан. Мөн дамжуулах хоолойн барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээг МГТБЗ ТӨХХК болон Норинко Интернейшнл компанитай, дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлэх гэрээг МГТБҮ ТӨХХК болон ЭТТ ХК-тай, нүүрс худалдах, худалдан авах гэрээг ЭТТ ХК болон Норинко Интернейшнл компанитай тус тус байгуулаад байна. МГТБҮ ТӨХХК-ийн газрын тос дамжуулах хоолойн төслийн инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажил гүйцэтгэх (EPC-F) гэрээ 2022 оны 7-р сараас хүчин төгөлдөр мөрдөгдөж, хуваарийн дагуу ажлууд эхэлсэн. Суурь судалгааны (инженер-геологи, геодези, геотехник) ажил, газрын тосны шинж чанарын болон урсацын шинжилгээ, судалгааг хийж гүйцэтгэж дуусаж, ажиллагсдын амьдрах түр кемп, технологийн зам барих, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон техникийн зураг төслийн ажлуудын гүйцэтгэл 80 гаруй хувьтай өрнөж байна. Дамжуулах хоолойн барилга, угсралтын ажлыг 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн гүйцэтгэж байна.	
23		2.2. Дамжуулах хоолой барих төслийн санхүүжилтийг эх үүсвэрийг шийдвэрлэж, трассын дагуух	2020 - 2024	-	Түүхий тос дамжуулах хоолой санхүүжилт шийдэгдэж, гүйцэтгэгчээр БНХАУ-ын Норико интернэйшнл кооперэйшн компани шалгарч зураг төслийг боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулж, барилга угсралтын ажил эхлүүлсэн байна. Дамжуулах хоолойн трассыг хээрийн судалгааны ажлын үр дүнд эцэслэн тодорхойлж, холбогдох орон нутгийн	100%

		газрыг улсын тусгай хэрэгцээнд авах ажлыг зохион байгуулна				удирдлагуудад байршлын солбицлуудын мэдээллийг хүргүүлж, ИТХ-уур шийдвэр гаргуулан, газрыг улсын тусгай хэрэгцээнд авах санал боловсруулж Яамнудаас санал авах ажлыг зохион байгуулж ажиллаж байна. Түгээх, халаах, өргөх, хүлээн авах 6 станцын газар эзэмшлийн асуудлыг шийдвэрлэж газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ, кадастрыг авсан.	
24	3.6.1. Эдийн засгийн өсөлтийг хангах, экспортыг нэмэгдүүлэх зам тээврийн сүлжээг өргөжүүлнэ:	5.1. Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замаас Өлзийт сум, Өлзийт сумаас Мөрөн-Тариалан чиглэлийн замын төгсгөлийг холбох 120км хатуу хучилттай авто зам төсөл /Концессын эргэн төлөлт/	2022 - 2023		77,122.0	Тухайн замыг концесс эзэмшигч компани дуусгаагүй тул 2023 оны улсын төсөвт тусгагдаагүй. Ажлыг бүрэн дуусгаж ашиглалтад өгсөн тохиолдолд эргэн төлөлтөд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсөвт тусгахаар байна тиймээс үнэлэх боломжгүй	100%
25		5.3. Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто зам төсөл	2020 - 2023		67074.2	ЭЗХЯ-наас "Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто зам" төсөл, арга хэмжээнд 96.1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохыг хүссэн албан бичиг ирүүлсэн. Тус хэлтсээс төслийн гүйцэтгэлийг хянан 4-р сарын 21-ний 03/2492 тоот албан бичгээр хууль, эрх зүйн актын холбогдох шаардлагыг хангаж гүйцэтгэлийг ирүүлэх шаардлагатай тухай чиглэл өгсөн. Санхүүжилтийн тооцоолол, валютын ханшны зөрүү тооцоог нягтлан бодит гүйцэтгэлийг гарган цахим систем болон цаасаар ирүүлэх чиглэл өгсөн.	100%

		/Концессын эргэн төлөлт/					
26	3.7.5. Орхоны хөндийд шинэ хотын суурьшлын бүсийн байршлыг судалж, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулна.	1. Орхоны хөндийд шинэ хотын суурьшлын бүсийн байршлыг судлан сонгох, шинэ хот байгуулахад шаардлагатай техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулна.	2020 - 2024		Орхоны хөндийд шинэ хотын суурьшлын бүсийн байршлыг сонгох судалгааны ажлыг зохион байгуулна.	2022 оны улсын төсөвт БХБС-ын багцад батлагдсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/" төсөл, арга хэмжээний хүрээнд тухайн төслийн санхүүжилтэд 261.0 сая төгрөг олгосон. Гэрээний үлдэгдэл болох 139.0 сая төгрөгийг 2023 оны улсын төсөвт БХБС-ын багцад батлагдсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/" батлагдсан эх үүсвэрээс зураг, төсвийн ажлын гүйцэтгэлийг үндэслэн олгох бөгөөд 4 дүгээр сарын байдлаар санхүүжилт аваагүй байна.- Үнэлэх боломжгүй	100%
ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО							
27	4.1.10. Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулна.	1. 4.1.10.Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулна.	2021 - 2024		Орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулна.	Төрийн албаны цалингийн нэгдсэн систем /ТАЦНС/-ийг нэвтрүүлэн, холбогдох нэмэлт хөгжүүлэлтийг тогтмол гүйцэтгэн ажиллаж байна. Систем хөгжүүлэлтийн төлөвлөгөөний дагуу ээлжит уулзалтыг зохион байгуулж, ТАХ-д тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн 36 сарын тэтгэмжийн хөгжүүлэлтийн явц, олговол зохих дүнгээр цалингийн гүйлгээ илгээх зорилгоор систем хооронд мэдээлэл солилцох, гүйлгээний төлөвийг харуулах, гүйлгээ илгээхэд үндэслэх баримт бичгийн шалгуур хийх зэрэг нэмэлт сайжруулалтын талаар хэлэлцэн, сайжруулах саналыг хөгжүүлэгчид хүргүүлсэн. ТАЦНС-ээс цалингийн гүйлгээг илгээж, Төрийн сангийн удирдлагын цахим систем /ТСУЦС/-ээр баталгаажуулах туршилтыг төсвийн орчинд гүйцэтгэж, төсвийн үр дүн, сайжруулах тухай саналыг хөгжүүлэгчид хүргүүлэн, бодит орчинд нэвтрүүллээ. Хувь хүний	100%

						орлогын албан татвар /ХХОАТ/-ын тайлангийн маягтад өөрчлөлт орж, иргэний бүртгэлийн 12 оронтой дугаараар тайлагнадаг болсон тул ТАЦНС-д тус өөрчлөлтийг оруулах саналыг боловсруулж, хөгжүүлэгчид хүргүүлэв. ТАЦНС-ийн сайжруулалт, шинэчлэлтийн цахим сургалтын систем www.surgalts.mof.gov.mn сайтад байршуулсан сургалтын бичлэгийг шинэчилсэн.	
28	4.2.2. Төрийн захиргааны байгууллагад чиг үүргийн иж бүрэн шинжилгээ хийж, чиг үүргийг оновчтой болгож, ажил үүргийн давхцалыг арилгах бодлогын шинэчлэлийг эхлүүлнэ.	3. Төрийн байгууллагад "цалингийн нэгдсэн систем"-ийг нэвтрүүлнэ.	2021 - 2024		Байгууллагын тоо 4000	Төрийн албаны цалингийн нэгдсэн систем/ ТАЦНС/-ийг бүх шатны төрийн байгууллагад бүрэн нэвтрүүлэн төрийн албан хаагчдын цалинг тус системээр тооцоолон олгож байна. 2023 оны 04 дүгээр сард төрийн болон албаны нууцын тухай хуульд зааснаас бусад 4,329 төсвийн байгууллагын давхардсан тоогоор 314,121 албан хаагчдын 222.6 тэрбум төгрөгийн цалинг Төрийн албаны цалингийн нэгдсэн систем/ТАЦНС/-ээр тооцоолж, Монгол банкны багцын гүйлгээний АСН+ системээр олголоо. Түүнчлэн цалингийн гүйлгээг ТСУЦС-ээр баталгаажуулах тухай zoom цахим уулзалтыг зохион байгуулж, системийн хэрэглэгчдэд дэмжлэг үзүүлж ажиллав. Төрийн сангийн дуудлагын төвийн лавлах дугаарт шууд холбогдох 13 яам, Нийслэл, 9 дүүрэг, 21 аймгийн төрийн сангийн төсвийн байгууллагуудын ахлах болон тооцооны нийт 305 нягтлан бодогчдын утасны дугаарын бүртгэлийг үүсгэсэн. ТСУЦС фейсбүүк чатбот, системийн лавлах утас 71001112, ips@mof.gov.mn цахим шууданд ирсэн ТАЦНС-ийн хэрэглэгчийн асуултад хариулт өгч, гарсан асуудлыг тухай бүр шийдвэрлэн ажиллав. ТСУЦС-ийн пэйж хуудсанд системтэй холбоотой мэдээ мэдээлэл бүхий пост оруулж эцсийн хэрэглэгчдэд мэдээлэл хүргүүлж ажиллав.	100%
29	4.2.5. Төрийн албан хаагчийн үйл	3. Төрийн захиргааны	2021 - 2024		Сургалт, сурталчилгааг	Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх ажлын хүрээнд	100%

	ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.	болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд өөрчлөлт оруулна. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.			явуулснаар үнэт зүйл, үндсэн зарчмаа хэрэгжүүлж, манлайллыг хангаснаар ёс зүйн зөрчил буурна.	Төрийн албаны зөвлөлөөс 2023 оны 04 дүгээр сарын 27-28-ны өдрүүдэд зохион байгуулсан зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн сургагч багш бэлтгэх сургалт"-д тус яамны ёс зүйн зөвлөлийн гишүүн, Хууль, эрх зүйн газрын ахлах шинжээч Л.Амгалан оролцож, гэрчилгээ авсан байна.	
30	4.5.5. Америкийн Нэгдсэн Улс, Япон, Европын Холбоо, Энэтхэг, Бүгд Найрамдах Солонгос Улс, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой "гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцааг өргөжүүлэн, эдийн	4. БНЭУ-тай Стратегийн түншлэлийг улам бэхжүүлж, БНЭУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийг	2021 - 2024	Газрын тосны үйлдвэрийн төслийн ажил урагшилна.	БНЭУ-ын санхүүжилтээр хэрэгжиж буй "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн санхүүжилтийн хүсэлтийг тухай бүрд нь шийдвэрлэдэг ба өнөөдрийн байдлаар 125,839,205 ам.долларын санхүүжилтийг шийдвэрлээд байна. Төслийн нийт ажлын гүйцэтгэл 10%-тай ЕРС-1 багц ажлын гүйцэтгэл 79%-тай, ЕРС-2, ЕРС-3 багц ажлын үндсэн гүйцэтгэгч шалгарч, гэрээ байгуулагдсан. 2021-2022 онд нийт 35.9 тэрбум төгрөгийн импортын татвараас чөлөөлсөн. Дамжуулах хоолойн трассын дагуу газрыг улсын тусгай хэрэгцээнд авах ажиллагаанд дэмжлэг үзүүлж байна. Түгээх, халаах, өргөх, хүлээн авах 6 станцын газар эзэмшлийн асуудлыг шийдвэрлэж газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ, кадастрыг авсан. Түүхий тос дамжуулах	90%	

	засгийн хамтын ажиллагааг бэхжүүлж, бусад улстай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллана.	хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.				хоолой санхүүжилт шийдэгдэж, гүйцэтгэгчээр БНХАУ-ын Норико интернэйшнл кооперэйшн компани шалгарсан. Үйлдвэрийн цахилгаан станцыг төвийн эрчим хүчний системтэй холбох дагалдах байгууламжуудыг цахилгаан эрчим хүчээр хангах "Ширээт" дэд станцын өргөтгөлийн ажил зураг төслийн шатандаа явж байна. 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн ЕРС-2 (Үйлдвэрийн үндсэн технологийн болон дагалдах байгууламж), ЕРС-3 (Дулааны цахилгаан станц) барих ажлын Ерөнхий гүйцэтгэгч "Megha Engineering and Infrastructures Limited" болон түүхий тос дамжуулах хоолойн бүтээн байгуулалтын ажлын Ерөнхий гүйцэтгэгч "Norico International Cooperation" компаниуд ажлаа эхлүүлээд байна.	
ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО							
31	5.1.12. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг 12.3 хувиар бууруулна.	2. Уур амьсгалын өөрчлөлтийн Парисын хэлэлцээрт оруулах үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийг хангана.	2020 - 2024		Эрчим хүч, хөдөө аж ахуй, барилга, тээвэр, аж үйлдвэр, хог хаягдлын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж, нүүрстөрөгчийн шингэлтийг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлсэн байна.	1. МУ-н ЗГ, АНУ-ын Мянганы сорилтын корпорац хооронд 2018 онд байгуулсан "Мянганы сорилтын компакт гэрээ II"-ний хүрээнд "Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл"-ийг АНУ-ын Мянганы сорилтын корпорацын 350.0 сая ам.долларын буцалтгүй тусламж, Монгол Улсын Засгийн газрын 111.76 сая ам.доллар нийт 462 сая ам долларын санхүүжилтээр 2021-2026 онд хэрэгжүүлнэ. Энэ нь Улаанбаатар хотын ирээдүйн нийт ус хангамжийг асуудлыг шийдвэрлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход чухал үүрэгтэй хөрөнгө оруулалт юм. 2. НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн санхүүжилтээр "НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцын хэрэгжилтийн талаарх Үндэсний дөрөвдүгээр-тайлан-илтгэл, Үндэсний хоёр жил тутмын хоёрдугаар тайлан боловсруулах төсөл 2019 оноос БОАЖЯ дээр хэрэгжиж байна. 3. Монгол-Солонгосын "Ногоон хэрэм" ойжуулалтын төслийн III үе шатны ажлыг хэрэгжүүлэх талаар харилцан ойлголцлын санамж бичигт Байгаль	90%

					орчин, аялал жуулчлалын яам, БНСУ-ын Ойн ерөнхий газар хооронд 2021 оны 9 дүгээр сард гарын үсэг зурсан бөгөөд төсөл нь 2022-2026 онд 5 жилийн хугацаанд 8,0 сая ам.долларын өртөгтэй хэрэгжинэ. Төслийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгонд ойн түймрийн хяналт, хамгаалалтын систем, түймрийн дараах ойжуулалт /600га/, Агро ойжуулалт, Байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, Мод үржүүлгийн газар, сургалт мэдээллийн төв байгуулах, “Тэрбум мод тарих санаачилга”-тай холбогдуулан Өвөрхангайд 15 га, Хөвсгөлд 15 га, Сэлэнгэд 15 га талбайд мод тарина. 4.“Байгаль орчинд ээлтэй эрчим хүчний эко хотхон” байгуулах төслийг Монгол Улсын Эрчим хүчний яамны харьяа “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨААТҮГ нь БНСУ-ын Өмнөд бүсийн эрчим хүчний консорциумтай хамтран Улаанбаатар хотын Налайх дүүрэгт хэрэгжүүлж байна. 5.БНПУ-ын хөнгөлөлттэй зээлийн 9 сая еврогийн санхүүжилтээр “Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах” төсөл 2019-2023 онд хэрэгжиж байна.	
ЗУРГАА. НИЙСЛЭЛ БА БУС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО						
32	6.2.6. Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, тус сангийн үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх, ил тод байдлыг сайжруулах, олон нийт оролцох, мэдээлэл хүргэх дэвшилтэт арга	1. Орон нутгийн хөгжлийн сангийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээг 21 аймгийн 330 суманд хийж, болзол хангасан сумдад өнгөрсөн оны ОНХС-ийн	2020 - 2024	ОНХС-ийн үр дүнг үнэлж дүгнэх, ил тод байдлыг сайжруулах, олон нийт оролцох, мэдээлэл хүргэх чанарыг дээшлүүлсэн байна.	Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр, хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор дотоодын барааны НӨАТ-ийн 5 хувийн эх үүсвэрийг хасаж, АМНАТ-ийн эх үүсвэр 5 хувь байсныг 2022 оноос 10 хувь болгон нэмэгдүүлсэн. Үүний үр дүнд ОНХС-ийн хөрөнгө 2023 онд өмнөх оноос 65.8 тэрбум төгрөг буюу 28.3 хувиар нэмэгдэж, 298.5 тэрбум төгрөг болж батлагдсан байна. ОНХС-ийн үр дүнг үнэлэх зорилготой жилийн гүйцэтгэлийн үнэлгээг 21 аймгийн 330 суманд хийж, үйл ажиллагааны хувьд болзол хангасан 218 суманд нийт 15.9 тэрбум төгрөгийн "урамшуулал"-ыг Тогтвортой амьжиргаа-3 төслийн санхүүжилтээр олгохоор	100%

<p>хэлбэрийг нэвтрүүлнэ.</p>	<p>санхүүжилтийн 25%-тай тэнцэх хэмжээний "урамшуулал" олгоно. ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системийг боловсруулж, үр дүнг үнэлж дүгнэх, ил тод байдлыг сайжруулах, олон нийт оролцох, мэдээлэл хүргэх чанарыг сайжруулна.</p>				<p>батлагдсан бөгөөд урамшууллыг 2023 оны 5-р сард сумдын ОНХС-д шилжүүлнэ. ОНХС-ийн үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах, олон нийт оролцох, мэдээлэл хүргэх чанарыг дээшлүүлэх зорилгоор ОНХС-ийн удирдлага мэдээллийн систем (www.onhs.mof.gov.mn)-д шаардлагатай шинэчлэл, хөгжүүлэлтийг хийсэн ба тус мэдээллийн системээс иргэд ОНХС-ийн төсөв, иргэдээс гарсан саналаас батлагдах хүртэлх үе шат бүрийн мэдээлэл, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тоон болон зураг, файл, текст байдлаар авах боломжтой. Мөн ОНХС-ийн www.tusuv-oronnutag.mof.gov.mn цахим хуудас, “Орон нутгийн хөгжлийн сан” гар утасны аппликейшн, www.facebook.com/LDFMongolia, twitter.com/LDF, www.youtube.com/ОронНутгийнХөгжлийнСан нийгмийн сүлжээний хуудаснууд, Фэйсбүүк дээрх “Орон нутгийн хөгжлийн сангийн нэгдсэн бүлэг” зэрэг мэдээллийн сувгуудыг ажиллуулж, иргэдэд мэдээлэл түгээж байна.</p>	
------------------------------	--	--	--	--	--	--